



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/83/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	411
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Алдааны залруулга.....	16
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.25 № 110

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.УРАНТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд улсын төсвөөс 658,282.1 мянга, орон нутгийн төсвөөс 87,366.4 мянга, нэмэлт санхүүжилтээр 4,358.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, гүйцэтгэлээр 723,218.2 мянган төгрөг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 7 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт 96.4 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,614,302.87	102,793,439.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	13,582,621.79
3121	Төгрөг	-	13,582,621.79
31211	Төрийн сангийн харилцах	-	13,582,621.79
33	АВЛАГА	319,910.60	-
335	Бусад авлага	319,910.60	-
3351	Байгууллагаас авах авлага	319,910.60	-
35	БАРАА МАТЕРИАЛ	83,294,392.27	89,210,817.21
354	Хангамжийн материал	76,419,392.27	73,841,904.41
35420	Аж ахуйн материал	9,754,554.21	8,953,454.21
35440	Түлш, шатах тослох материал	1,294,452.50	165,000.00
35460	Хүнсний материал	1,037,922.90	-
35470	Бусад хангамжийн материал	64,332,462.66	64,723,450.20
35500	Биологийн хөрөнгө	-	1,718,912.80
35600	Мал амьтад	6,875,000.00	13,650,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,746,066,351.77	1,885,096,253.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,746,066,351.77	1,885,096,253.12
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,720,660,351.77	1,858,550,253.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,729,997,330.91	1,729,997,330.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	(100,117,636.34)	(151,413,003.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,300,000.00)	(3,900,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	197,232,091.20	238,364,787.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,733,303.27)	(47,421,935.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,657,032.00	80,888,620.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,871,404.13)	(15,535,752.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,927,500.00	3,927,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,606,499.88)	(2,092,001.64)
39217	Ном	17,475,241.28	19,734,707.36
393	Биет бус хөрөнгө	25,406,000.00	26,546,000.00
39301	Програм хангамж	1,075,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(775,000.00)	(360,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,672,636.00	25,672,636.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(566,636.00)	(566,636.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,829,680,654.64	1,987,889,692.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	125,000.00	3,758,043.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	125,000.00	3,758,043.30
413	Өглөг	125,000.00	3,758,043.30

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	125,000.00	3,078,043.30
4136	Бусад өглөг	-	680,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	680,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,829,555,654.64	1,984,131,648.82
51	Засгийн газрын хувь оролцоо	1,829,555,654.64	1,984,131,648.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287,712,364.56	287,712,364.56
51101	Өмч: - төрийн	287,712,364.56	287,712,364.56
512	Хуримтлагдсан үр дүн	1,526,936,579.88	1,681,512,574.06
51210	Өмнөх үеийн үр дүн	1,570,735,283.43	(450,927,637.01)
51220	Тайлант үеийн үр дүн	(43,798,703.55)	2,132,440,211.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,906,710.20	14,906,710.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,829,680,654.64	1,987,889,692.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	586,478,032.69	2,793,011,229.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,491,968.69	2,047,362,718.12
120	Нийтлэг татварын бус орлого	14,491,968.69	2,047,362,718.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,491,968.69	2,047,362,718.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,417,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,857,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,491,968.69	2,043,088,018.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,986,064.00	745,648,511.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521,751,700.00	658,282,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	658,282,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	521,751,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,461,064.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,825,664.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,635,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,773,300.00	87,366,411.84
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,773,300.00	87,366,411.84
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	630,276,736.24	808,993,206.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,276,736.24	808,993,206.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,062,321.02	760,614,061.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,630,767.63	505,925,484.42
210101	Үндсэн цалин	305,987,563.64	391,001,306.58
210102	Нэмэгдэл	77,423,212.86	87,777,712.48
210104	Урамшуулал	27,599,991.13	27,146,465.36
210105	Гэрээт ажлын хөлс	1,620,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,439,256.56	63,947,317.77
210201	Тэтгэврийн даатгал	39,942,456.56	43,764,484.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,624,100.00	5,109,057.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,899,200.00	4,062,492.25

210204	Ажилгүйдлийн даатгал	724,900.00	1,001,043.99
210205	Эрүүл мэндийн даатгал	7,248,600.00	10,010,239.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,454,004.21	34,907,894.16
210301	Гэрэл, цахилгаан	10,001,555.41	11,833,144.76
210302	Түлш, халаалт	14,097,948.80	18,625,249.40
210303	Цэвэр, бохир ус	1,354,500.00	4,449,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,508,390.00	10,980,070.00
210401	Бичиг хэрэг	946,550.00	-
210402	Тээвэр, шатахуун	831,950.00	935,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	515,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,114,890.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	10,045,000.00
2105	Нормативт зардал	21,488,127.60	32,462,139.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	330,000.00	-
210502	Хоол, хүнс	20,679,647.60	32,462,139.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	478,480.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,874,580.00	9,384,030.00
210604	Урсгал засвар	8,874,580.00	9,384,030.00
2107	Томилолт, зочны зардал	153,600.00	-
210702	Дотоод албан томилолт	153,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,313,053.00	5,003,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,313,053.00	1,417,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,586,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,200,542.02	98,003,625.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,405,000.00	18,205,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,809,260.00	7,011,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,986,282.02	72,785,855.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,214,415.22	48,379,144.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,894,604.37	44,931,986.36
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,230,330.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,664,274.37	38,449,886.36
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,482,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,319,810.85	3,447,158.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,319,810.85	3,447,158.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(43,798,703.55)	1,984,018,023.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	81,285.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	81,285.43
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(81,285.43)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(43,798,703.55)	1,983,936,738.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	571,986,064.00	749,923,211.84

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,274,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,274,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,274,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,417,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,857,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,986,064.00	745,648,511.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	521,751,700.00	658,282,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	658,282,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	521,751,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,461,064.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,825,664.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,635,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,773,300.00	87,366,411.84
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,773,300.00	87,366,411.84
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	565,478,564.00	719,631,909.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,478,564.00	719,631,909.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,742,323.15	671,181,563.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	413,369,344.24	505,925,484.42
210101	Үндсэн цалин	306,726,140.25	391,001,306.58
210102	Нэмэгдэл	77,423,212.86	87,777,712.48
210104	Урамшуулал	27,599,991.13	27,146,465.36
210105	Гэрээт ажлын хөлс	1,620,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,068,250.00	63,947,317.77
210201	Тэтгэврийн даатгал	39,571,450.00	43,764,484.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,624,100.00	5,109,057.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,899,200.00	4,062,492.25
210204	Ажилгүйдлийн даатгал	724,900.00	1,001,043.99
210205	Эрүүл мэндийн даатгал	7,248,600.00	10,010,239.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,423,651.91	33,778,441.66
210301	Гэрэл, цахилгаан	10,001,555.41	11,833,144.76
210302	Түлш, халаалт	14,067,596.50	17,495,796.90
210303	Цэвэр, бохир ус	1,354,500.00	4,449,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,225,390.00	-
210401	Бичиг хэрэг	829,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	704,850.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	515,000.00	-
210404	Ном, хэвлэл	30,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,046,040.00	-
2105	Нормативт зардал	23,645,244.00	30,807,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	330,000.00	-
210502	Хоол, хүнс	22,407,214.00	30,807,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	908,030.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,413,080.00	9,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	180,000.00	-
210604	Урсгал засвар	7,233,080.00	9,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	153,600.00	-
210702	Дотоод албан томилолт	153,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	5,514,953.00	4,903,500.00

	үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,514,953.00	1,417,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,486,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,928,810.00	22,819,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,351,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,928,810.00	7,467,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,736,240.85	48,450,345.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,416,430.00	45,003,186.86
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,230,330.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,186,100.00	38,521,086.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,482,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,319,810.85	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,319,810.85	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,447,158.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,447,158.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,507,500.00	30,291,302.79
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,507,500.00	16,708,681.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,507,500.00	16,708,681.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,507,500.00	16,708,681.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,507,500.00	16,708,681.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,507,500.00)	(16,708,681.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	13,582,621.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,582,621.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бу сад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Өмчид гарсан өөрчлөлт	287,712,364.56	14,906,710.20	1,570,735,283.43	-	1,873,354,358.19
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,798,703.55)	-	(43,798,703.55)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,712,364.56	14,906,710.20	1,526,936,579.88	-	1,829,555,654.64
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	287,712,364.56	14,906,710.20	1,526,936,579.88	-	1,829,555,654.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,829,360,744.04)	-	(1,829,360,744.04)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,712,364.56	14,906,710.20	(302,424,164.16)	-	194,910.60
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,983,936,738.22	-	1,983,936,738.22
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,712,364.56	14,906,710.20	1,681,512,574.06	-	1,984,131,648.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	770,754,300.00	732,893,431.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	770,754,300.00	732,893,431.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,953,700.00	687,890,244.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,949,700.00	505,925,484.42
210101	Үндсэн цалин	396,955,000.00	391,001,306.58
210102	Нэмэгдэл	106,089,600.00	87,777,712.48
210104	Урамшуулал	14,905,100.00	27,146,465.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,698,200.00	63,947,317.77
210201	Тэтгэврийн даатгал	44,025,700.00	43,764,484.92
210202	Тэтгэмжийн даатгал	5,179,500.00	5,109,057.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,143,600.00	4,062,492.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1,031,900.00	1,001,043.99
210205	Эрүүл мэндийн даатгал	10,317,500.00	10,010,239.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,488,200.00	33,778,441.66
210301	Гэрэл, цахилгаан	11,900,000.00	11,833,144.76
210302	Түлш, халаалт	41,088,200.00	17,495,796.90
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,449,500.00
2105	Нормативт зардал	30,807,700.00	30,807,700.00
210502	Хоол, хүнс	30,807,700.00	30,807,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,971,900.00	6,403,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,985,700.00	1,417,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,986,200.00	4,986,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,038,000.00	38,027,801.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,558,700.00	30,548,501.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,479,300.00	7,479,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,800,600.00	45,003,186.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,800,600.00	45,003,186.86
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,318,500.00	38,521,086.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,482,100.00	6,482,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	765,911,200.00	745,648,511.84
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	765,911,200.00	745,648,511.84
122005	Орон нутгийн төсвөөс	765,911,200.00	745,648,511.84
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,582,621.79

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэдтөлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадварбүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Сангийн яамны 2023 оын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388, 32-дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”, “Сангийн сайдын 2008 оны Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримтлал болгон бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 158,209.0 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	13,582.6	13,582.6
Бараа материал	83,294.4	89,210.8	5,916.4
Үндсэн хөрөнгө	1,746,066.4	1,885,096.3	139,029.9
Нийт хөрөнгө	1,829,680.6	1,987,889.7	158,209.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,829,555.6	1,984,131.6	154,576.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,829,680.6	1,987,889.7	158,209.0

Нийт орлого 2,206,533.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндэслэн үндсэн хөрөнгө, бараа материалын эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,582.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,885,096.3 мянган төгрөг болж, 139,029.9 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар, бараа материалын үлдэгдэл 89,210.8 мянган төгрөг болж 5,916.4 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар тус тус өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 178,716.5 мянган төгрөг буюу 22.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нэмэгдэл, хоол хүнсний зардалтай холбоотой байна. Цалингийн зардал 93,294.7 мянган төгрөг, хоол хүнсний зардал 11,782.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 841,947.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 71,192.7 мянган төгрөгөөр бууруулж, 770,754.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 770,754.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 658,282.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын төсвөөс санхүүжүүлж, орон нутгийн төсвөөс 87,366.4 мянган төгрөг, өөрсдийн үйл ажиллагааны орлогоор 4,358.7 мянган төгрөгийн санхүүжилт хийгджээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81801- Үдийн цай хөтөлбөр	39,318.5	38,521.1	797.4	97,97%
2	81806-Дотуур байрны үйлчилгээ	46,594.6	45,159.6	1,435.0	96,92%
3	81816- Зөв Монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	11,990.0	11,986.4	3.6	99,97%
4	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	4,487.6	4,487.6	-	100%
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	456,493.6	448,160.4	8,333.2	98,17%
6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	94,112.5	91,105.7	3,006.7	96,81%
7	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,994.5	1,994.5	-	100%%
8	80312-Сургалт семинар	997.2	996.2	0.98	99,90%
9	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,293.6	2,288.0	5.6	99,76%
10	81848-Сурах бичиг түрээс	1,985.7	1,417.3	568.4	71,38%
11	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	66,488.2	42,778.4	23,709.8	64,34%
12	80112-Нийтлэг үйлчилгээ	41,140.9	41,140.8	0.09	100%
13	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	2,857.4	2,857.4	-	100%
НИЙТ		770,754.3	732,893.4	37,860.9	95,0%

Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 23,709.8 мянган төгрөг, сурах бичгийн түрээс 568.4 мянган төгрөг, нийтлэг үйлчилгээний санхүүжилт 0.09 мянган төгрөг нийт 24,278.2 мянган төгрөгийн санхүүжилт тус тус дутуу олгогдсон байна. Улсын төсвийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээний эцсийн үлдэгдэл нь 13,582.6 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн МНБ,ТМЗ, аудитор С.Энхтөр, аудиторын туслах Ш.Ундрах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 6,302.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,411.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд түлш, халаалтын зардал 3,428.2 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардал 1,831.6 мянган төгрөг, хоол хүнсний зардал 8,400.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Түлш, халаалтын зардал: Түлш шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор нүүрс хөрзөн бэлтгэх тээврийн зардал өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.
- Хоол хүнсний зардал өмнөх оноос дунжаар 27.0 хувиар нэмэгдсэн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээллэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	1	3,167.5	1	3,167.5	100%
Төлбөрийн акт	1	1,037.9	1	1,037.9	100%
Албан шаардлага	1	620.0	1	620.0	100%
Зөвлөмж	3	2,777.3	3	2,777.3	100%
Нийт дүн	6	7,602.7			100.0%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,528.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,809.3 мянган төгрөгийн алдааг залруулж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 1,718.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

5.1 Залруулсан алдаа

Татварын цахим системд ХХОАТ-ыг 3,809.3 мянган төгрөгөөр илүү тайлагнаж илгээснийг тулгаж, санхүүгийн тайлан болон татварын тайланд залруулсан.

5.2 Зөвлөмж

1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн номыг эдийн засгийн ангиллаар үнэн зөв бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллаар буруу бүртгэгдсэн түрээсийн номыг тохирох эдийн засгийн ангиллын дагуу шилжүүлэн бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Татварын цахим системд ХХОАТ-ыг илүү тайлагнаж илгээснийг суутгасан татвартай тулгаж залруулсан.	1	3,809.3					1	3,809.3				
Нийт дүн	1	3,809.3					1	3,809.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Түрээсийн номыг эдийн засгийн ангилалаар /биологийн хөрөнгө / буруу бүртгэж тайлагнасан.	1	1,718.9						1	1,718.9				
Нийт дүн	1	1,718.9						1	1,718.9				